

Хүнс, хөдөө аж ахуйн газар
2015 оны 09 дугаар сард зохион байгуулсан ажлын тайлан

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар

Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсгийг Газрын даргын 2015 оны 57 тушаалаар байгуулж бэлтгэл хангаж, ажлыг зохион байгуулав. 9 дүгээр сарын 21-ны өдөр улсын үзлэгийн ажлын хэсэгт ажлаа шалгуулж, холбогдох заавар, зөвлөгөөг авлаа.

Мөн төрийн байгууллагуудаас хууль, эрх зүйн чиглэлээр сургалт авах төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулан төлөвлөгөөний дагуу аймгийн Хөдөлмөрийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтсээс сургалтууд авлаа.

Мөн тус газрын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж газрын даргын 2015 оны 63 тоот тушаалаар батлаж хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.

Хоёр:Салбарын хүрээнд

Мал аж ахуй салбар:

Монгол Улсын Засгийн газрын 292 дугаар тогтоол, 2015-2016 оны хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн бэлтгэл хангуулах” тухай Улсын онцгой комиссын 2015 оны 7 дугаар сарын 06-ны №03 тоот хурлын шийдвэр, хөдөө аж ахуйн салбарын 2015-2016 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2015-2016 онд аймгийн мал, сүргийг өвөлжүүлж, хаваржуулахад хонин толгойд шилжүүлснээр 704,1 мянган тоо толгой малд шаардагдах 67.7 мянган тн өвс 352,1 тн ногоон тэжээл, 633,8 тн үйлдвэрийн тэжээл, 704,1 тн гар тэжээл бэлтгэхээс Тус газрын даргын 2015 оны 16-45 тоот дугаартай тушаалуудыг хянуулахаар хүргүүлэв.

Аймгийн нөөцийг Сэлэнгэ аймгийн Хушаат сумаас 5000 боодол буюу 100 тн өвснөөс 3315 боодол буюу 66 тн өвсийг Улсын нөөцийн өвсний агуулахад хадгалж эхлээд байна. Мөн Хонгор сум 100 тн хадлан бэлтгэхээр гэрээ байгуулсанаас 2884 боодол буюу 57 тн, Орхон сум 20 тн хадлан бэлтгэхээр гэрээ байгуулсанаас 720 боодол буюу 14 тн өвсийг нөөцөлж эхлэсэн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 122 тогтоолын дагуу 4 сумаас 302 малчин өрхийн материалыг ХХААЯ-ны Мал хамгаалах санд хүргүүлээд байна.

Шилмэл мал-2015 үзэсгэлэн худалдаанд Дархан сумын 2 иргэн 96 толгой тэжээвэр амьтан оролцож, Иргэн Сарантуяа шилдэг оролцогчоор шагнуулсан байна.

УМЭҮГ-аас Орон нутгийн малын үржлийн ажил үйлчилгээний чадавхи нэмэгдүүлэх сургалт, семинар Улаанбаатар хотноо 2 хоног зохион байгуулагдаж Мал аж ахуйн хэлтсийн дарга оролцлоо.

Мал эмнэлгийн салбар

Намрын мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ эхлэж байгаатай холбогдуулан шаардагдах эм бэлдмэлийг Биокомбинат төрийн өмчит Улсын үйлдэвэрийн газраас татан авч, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдэд хувиаарлан олгож тарилгын ажлыг зохион байгуулснаар боом, цусан халдварт, дуут хавдар, бруцеллёз, сахуу зэрэг халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээнд өссөн дүнгээр 90,6 мянган толгой малыг хамруулаад байна. Паразит өвчнөөс сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалтанд давхардсан тоогоор 156,9 мянган толгой малыг хамруулж, өвөлжөө хашааны ариутгал, халдваргүйжүүлэлтийг 268 өрхийн 384 өвөлжөө хашааны 62,8 мянган мкв талбайд хийсэн байна. Хүнсний зах болон төмөр замын вокзалын орчим ажиллаж байгаа түр захад худалдан борлуулж байгаа малын гаралтай түүхий сүү, боловсруулсан цагаан идээнээс долоо хоногт 3 дээж аван мал эмнэлгийн эрүүл ахуй ариун цэврийн шинжилгээ хийж баталгаажуулж байна. Төвийн бүсийн аймгуудыг шүлхий өвчнөөс эрүүл тайван болохыг баталгаажуулах зорилгоор тандалт шинжилгээ хийх бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээний хүрээнд Монгол улсын Мал эмнэлэг ариун цэврийн Төв лабораторитой хамтран ажиллах гэрээ байгуулан шинжилгээнд шаардагдах эм урвалж, оношлууур болон шатахуун, томилолтын зардлын тооцоог гарган хүргүүлээд байна. Тандалт шинжилгээ хийх ажлыг 10-р сарын 20-ны дотор багтаан зохион байгуулах бэлтгэл ажлыг бүрэн хангаад байна. Үүнээс гадна гахайн мялзан өвчнийг эрт илэрүүлэх, эрүүлийг баталгаажуулах болон гахайд түгээмэл тархалттай вирусийн гаралтай зарим өвчний тандалт шинжилгээ хийх ажлыг зохион байгуулж байна.

Газар тариалангийн салбар

Нийт үр тариа, төмс, хүнсний ногоо 20857.2 га-д тариалалт хийсэнээс 14457 га-д буудай, 200 га-д гурвалжин будаа, 4809 га-д тосны ургамал, 528 га-д төмс, 935.2 га-д хүнсний ногоо, 132 га талбайд малын тэжээлийн ургамал тариалалт хийсэн байна.

Аймгийн хэмжээнд нийт нутгаар гангийн нөхцөл байдал үүссэн нь таримал ургамлын ургалтанд муугаар нөлөөлж урьдчилсан байдлаар 14.4 мянган га-д үр тариа тариалснаас 3841.5 га ургац алдаж 10349.1 га-аас 7552.9 тонн буюу га-аас 7.3 цн улаан буудай хураан авах төлөвтэй байна. Үүнээс 800 тонныг нь ирэх оны тариалалтад, 200 тонныг нь үрийн нөөцөд, 6472.9 тонныг гурилын үйлдвэрлэлд нийлүүлэхээр урьдчилсан байдлаар төлөвлөөд байна. Төмс 2100 тонн, хүнсний ногоо 5618.1 тонн, 672.6 тонн тосны ургамал хурааж авах урьдчилсан тооцоог гаргалаа.

Урьдчилсан байдлаар үр тарианы ургац өмнөх оны гүйцэтгэлээс төмс 7.5 мянган тонноор, хүнсний ногоо 4626 тонноор, тосны ургамал 3276.3 тонноор тус тус бага ургац хураан авах урьдчилсан баланстай байна.

Аж ахуйн нэгж, иргэдээс ирсэн хүсэлтийн дагуу буудайн үрийн талбайд хянан баталгааг УГТХүрээлэн, МХГазар, Улсын үрийн нөөцтэй хамтран зохон

байгууллаа. Хянан баталгаанд 7 аж ахуйн нэгжийн 836 га талбай хамрагдаж 4 сортын 739.6 га-ын буудай үрэнд тэнцсэн байна.

Уринш боловсруулалтыг 12500 га хийхээр төлөвлөсөн бөгөөд өнөөдрийн байдлаар 10957.1 га-д буюу 87.6 хувиар гүйцэтгэлтэй байна.

09 дүгээр сарын 21-ны байдлаар 2140 га талбайгаас 1210 тонн үр тариа, 196 га-аас 1020 тонн төмс, 359 га-аас 2124 тонн хүнсний ногоо тус тус хураан аваад байна. Үр тарианы хураалт 19.7%, төмсний хураалт 65.6%, хүнсний ногооны хураалт 57.3%, нийт ургац хураалт 24.1 хувьтай байна. Одоогоор нэг га талбайгаас 5.6 цн буудай, 52.0 цн төмс, 59.2 цн хүнсний ногоо хураан авч байна.

Тайланг нэгтгэсэн: Архив, Бичиг хэргийн эрхлэгч Д.Ганбаяр

Тайланг хянасан: ЗУХэлтсийн дарга Б.Бат-Эрдэнэ

БАТЛАВ: ХХААГ-ЫН ДАРГА

Ц.ЭНХЖАРГАЛ

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
2015 ОНЫ 10 ДУГААР САРД ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хийгдэх ажил	Огноо	Хариуцах эзэн	Хүрэх үр дүн
Захиргаа удирдлагын хэлтэс				
1	Дархан хотын баярыг угтаж байгууллагын хэмжээнд бүтээлч ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.	10 сард	Хэлтсийн дарга нар	Бүтээлч ажлуудыг зохион байгуулж байгууллагын тохижилт сайжирна.
2	Тайлангуудад ХШҮнэлгээ хийж газрын зөвлөлд танилцуулах.	10 сард	ХШҮнэлгээний баг	Хэрэгжилт хангалтгүй байгаа заалтууд Удирдлагын бүрэлдэхүүнд танилцуулагдсан байна.
3	Архив, албан хэрэг хөтлөлтийн ажлуудыг	10 сард	Ажлын хэсэг	Архив, албан хэрэг

	үргэлжлүүлэн зохион байгуулах.			хөтлөлтийн заавар, стандартыг хэрэгжилт сайжрана.
4	Төрийн байгууллагуудаас хуваарийн дагуу сургалтуудыг авах.	10 сард	Б.Бат-Эрдэнэ	Албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэг нэмэгдэнэ.
Мал аж ахуйн хэлтэс				
4	Өвөлжилтийн тайланг гаргаж, ХХААЯ-д хүргүүлэх.	Сардаа	МААХ	Өвөлжилт, хаваржилтийн тайланг холбогдох хүснэгт дагуу гаргасан байна.
5	Богийн зохиомол хээлтүүлгийн мэдээг авч нэгтгэх.			МААЭШХ-ийн нарийн, нарийвтар ноост хонины хээлтүүлгийн мэдээг нэгтгэсэн байна.
6	Мал аж ахуйн чиглэлээр аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээлийн эргэн төлөлтийн тайланг гаргах.			МХС-аас олгосон зээлийн эргэн төлөлт хийгдсэн байна.
Мал эмнэлгийн хэлтэс				
7	Шүлхийн тандалт шинжилгээ хийх	10-р сарын 20-ны дотр	Мал эмнэлгийн хэлтэс	Эрүүлийг баталгаажуулах
8	Гахайн мялзангийн тандалт шинжилгээ хийх	10-р сарын 20-ны дотр		Эрт илэрүүлэх
9	Бруцеллёзын тарилга хийх ажлыг дуусгаж, холбогдох баримт, материалыг бүрдүүлэн МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Мал	10-р сарын 28-ны дотор		Тарилганд бүрэн хамруулж, санхүүжилтийг олгосон байна.

	эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэх			
10	Намрын урьдчилан сэргийлэх тарилга хийсэн акт, материалыг анхан шатны нэгжүүдээс бүрдүүлэн авч, хянаж үзэх	10-р сарын 28-ны дотор		Товлолын дагуу бүрэн хийгдсэн байна.
11	Хавар, намрын урьдчилан сэргийлэх тарилга хийсэн ажлын үйлчилгээний хөлсний санхүүжилтийг анхан шатны нэгжүүдэд олгуулах	10-р сарын 15-ны дотор		Санхүүжилтийг шилжүүлсэн байна.
12	3-р улиралын мэдээ, тайланг гарган МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Мал эмнэлэг, үржлийн газарт хүргүүлэх	10-р сарын 05-ны дотор		Хугацаандаа хүргүүлсэн байна.
Хүнс, газар тариалангийн хэлтэс				
11	Дархан хотын баяр үзэсгэлэн худалдааг зохион байгуулах	IX/25-IX/27	ХГТХэлтэс	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэнэ
12	“Намрын ногоон өдрүүд-2015” улсын үзэсгэлэн худалдаанд оролцох	IX/29 – X/ 05		Үзэсгэлэн худалдаанд оролцсон байна
13	Ургац хураалтын мэдээг гаргах	7 хоногт 2удаа		ХХААЯ, ХБХ-т мэдээ хүрсэн байна.